

Доорх өдөр хүртэл хориглосон.

2022 ОНЫ 12-Р САРЫН 15-НЫ ПҮРЭВ ГАРАГ 15:00 (EST) ЦАГ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБОО БАРИХ ХҮМҮҮС

Анжела Кэмпбелл (TNC Global Media, Вашингтон хот) angela.campbell@tnc.org, +1-571-279-5598

Клэйр Гриффин (TNC Global Media, Монреаль) claire.griffin@TNC.ORG

Эндрью Хармон (Монгол) andrew.harmon@tnc.org

Майк Пфланз (Габон) mikepflanz@gmail.com

Лора Маргисон (Enduring Earth) lmargison@pewtrusts.org

МОНРЕАЛЬ: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Талуудын 15-р уулзалт үргэлжилж буй энэ цаг мөчид Габон, Монгол хоёр улс “The Nature Conservancy” байгууллагатай (Канад улс дахь [Nature United](#) байгууллагын олон улсын салбар) хамтран 2030 он гэхэд эх газар, цэнгэг ус, далай тэнгисийн нөөцийн 30 хувийг хамгаалах том зорилтыг хэрэгжүүлэхэд дэлхийд тэргүүлэхээр зорьж байгаагаа зарлаж байна

Эдгээр амлалтын нийт нөлөө нь Япон улстай ойролцоо хэмжээтэй буюу 380,000 хавтгай дөрвөлжин километр газар нутаг, далай тэнгисийн тусгай хамгаалалттай газар нутгаас хэтрэх төлөвтэй байгаа бөгөөд нутгийн иргэд, зэрлэг ан амьтад, амьдрах орчинд нь сайн үр нөлөө үзүүлэхийн төлөө нутгийн иргэдтэй хамтран цэнгэг усны нөөцийг хамгаалах, байгаль хамгаалах менежментийг сайжруулахад ихээхэн хүчин чармайлт гаргана. Тус хоёр санаачилгад Тогтвортой байдлын төслийн санхүүжилт (ТБТС) хэмээх арга барилыг ашиглах бөгөөд энэ нь их хэмжээний газар нутагт байгаль хамгаалахын тулд өргөн хүрээний эвслийг бий болгодог.

“The Nature Conservancy” байгууллагын Гүйцэтгэх захирал [Женнифер Моррис](#) хэлэхдээ “Дэлхий ертөнцийн биологийн олон янз байдал урьд хожид үзэгдээгүй их хэмжээгээр алдагдаж байна. “2030 он гэхэд энэ алдагдлыг нөхөхийн тулд илүү олон улс орны засгийн газрууд байгаль орчинд илүү их хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй байна. Тогтвортой байдлын төслийн санхүүжилт (ТБТС) эх газар, далай тэнгис, цэнгэг усыг хамгаалах, мөн биологийн олон янз байдал, уур амьсгалын хямралыг хамтран шийдвэрлэх, нутгийн иргэддээ хөрөнгө оруулах, олон улсын өмнө өгсөн амлалтаа биелүүлэх санхүүгийн ямар хүчирхэг хэрэгсэл болохыг Габон, Монгол улс өнөөдөр харуулж байна” гэв.

Тогтвортой байдлын төслийн санхүүжилт (ТБТС)-ийн тус хоёр санаачилга хүн, дэлхий ертөнцийн илүү тогтвортой, цэцэглэн хөгжсөн ирээдүйн төлөө байгаль хамгаалах ажлыг эрчимжүүлж, нэмэгдүүлэхийн зэрэгцээ улс оронтой мөр зэрэгцэн ажилладаг [Enduring Earth](#) байгууллагын ивээл доор цааш урагшлах юм. “Enduring Earth” байгууллага “The Nature Conservancy”, “The Pew Charitable Trusts”, Дэлхийн зэрлэг амьтдыг хамгаалах сан (WWF), “ZOMALAB”, Бен, Люси Ана Уолтон нарын гэр бүлийн албадаас бүрддэг.

“Enduring Earth” байгууллагыг бүрдүүлдэг байгууллагууд өмнө нь таван улсад (Коста Рика, Канад, Перу, Бутан, Бразил) энэ аргыг хэрэглэж, дэлхий даяар 90 сая гаруй га газрыг хамгаалсан. Энэ оны эхээр Дэлхийн зэрлэг амьтдыг хамгаалах сан (WWF) Колумб улсад шинэ [ТБТС-ийн төсөл](#) зарласан бөгөөд энэ нь “Enduring Earth” байгууллагын ивээл доор хэрэгжих хамгийн анхны төсөл юм.

“ТБТС загвар дэлхийн хэмжээнд 100 сая гаруй га эх газар, далай тэнгис, цэнгэг усыг хамгаалж чадсан баталгаажсан арга юм. Энэ арга засгийн газруудад биологийн олон янз байдал, уур амьсгал, нутгийн иргэдийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх тодорхой чиглэл өгөхөөс гадна урт хугацаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөөцөөр хангах замаар 2030 он гэхэд экосистемийн 30-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах зорилгыг биелүүлэхэд туслаад зогсохгүй хадгална” гэж “Enduring Earth” байгууллагын Захирал Зденка Пистулич хэлэв.

Пүрэв гарагт болсон арга хэмжээний үеэр улс орнуудын удирдагч нар Габон, Монгол хоёр улсын зорилгын талаар ярилцаж, биологийн олон янз байдлыг санхүүжүүлэхийн тулд нөөцийг дайчлах нийтлэг зарчмуудыг хэрэгжүүлэхээ хэд хэдэн улс орнууд нэмж амлав. 9-р сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей дээр танилцуулсан 10 заалт бүхий төлөвлөгөөнд 25 улс нэгдэв. Эквадор, Габон, Мальдив, Их Британи улс тэргүүлсэн энэ төлөвлөгөө Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Талуудын 15-р уулзалтын үеэр байгаль хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, 2020 оноос хойших Олон улсын биологийн олон янз байдлын том зорилготой хүрээг хүлээн зөвшөөрөхийг уриалж буй олон улсын хүчин чармайлтыг дэмжинэ.

Пүрэв гаригийн үдээс хойш 2030 он гэхэд эх газар, далай тэнгис, цэнгэг усны 30 хувийг хамгаалах амлалтаа биелүүлэх [байгаль хамгааллын өргөн хүрээний хүчин чармайлт](#) дээр хамтран ажиллах гэрээнд Габон улсын засгийн газар, “The Nature Conservancy” байгууллага гарын үсэг зурна. Габон улс ийм гурван амлалт өгсөн анхны орон юм. Тогтвортой байдлын төслийн санхүүжилтээр (ТБТС) 24,000 гаруй хавтгай дөрвөлжин километр ой мод, 8,000 гаруй хавтгай дөрвөлжин километр далай, 4,800 км гол мөрнийг хамгаалах төлөвтэй байна. Ойн менежментийг сайжруулснаар нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг жилд 30 сая тонноор бууруулах төлөвтэй байна.

“Габон улс биологийн олон янз байдлыг хамгаалахад байгалийн бүх тогтолцоог тусгах хүчин чармайлтаараа дэлхийд тэргүүлж байгаа бөгөөд тус улсын уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд гаргасан ололт амжилтын зэрэгцээ энэ Тогтвортой байдлын төслийн санхүүжилт (ТБТС) тус улсын эдийн засгийг чөлүүжсэн түлшнээс тогтвортой байгальд тулгуурласан аж ахуй болгон хувиргах Габон улсын тэргүүлэх байр суурийг улам бэхжүүлнэ.” гэж “The Nature Conservancy” байгууллагын Габон улс дахь Үйл ажиллагаа хариуцсан захирал Мари-Клэйр Пэйз хэлэв.

Маргааш Монгол улсын удирдагч нар “TNC”, “Enduring Earth” байгууллагын төлөөлөгчидтэй уулзаж, энэ оны эхээр байгуулсан гэрээний талаар мэдээлэл солилцож, байгаль хамгаалах амлалтаа өгнө.

Тус санаачилга Монгол улсын хэмжээнд 144,000 хавтгай дөрвөлжин километр тусгай хамгаалалттай газар нутгийг шинээр бий болгож, 426,000 хавтгай дөрвөлжин километр тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах төлөвтэй байна. Энэ хүчин чармайлт дэлхийн [хамгийн том онгон зэлүүд бэлчээрийн](#) ихэнх хэсэг, мөн ховордсон нүүрстөрөгч агуулсан хүлэрт газар, тайга, чөлөөтэй урсах гол мөрөн, цасны ирвэс зэрэг ховордсон амьтдын амьдрах орчныг хамгаална. Дэлхий дээр үлдсэн сүүлчийн нүүдэлчдийн соёлыг төлөөлж буй нутгийн малчин иргэд тус хүчин чармайлтын анхаарлын төвд байгаа бөгөөд тэд бэлчээрийг хамгаалж, удирдсан хэвээр байна.

“Байгалийн нөөцийн менежментэд нутгийн иргэдийн манлайлал чухал ач холбогдолтой байдгийг монголчууд эртнээс хүлээн зөвшөөрсөн бөгөөд байгалийн олон янз байдлын талбайг хамгаалж, удирдах энэ хамтын арга хэлбэрийг цаашид ч үлгэрлэн харуулна” гэж “The Nature Conservancy” байгууллагын Монгол улс дахь Төлөөлөгчийн газрын захирал Даваагийн Галаа хэлэв.

Өнгөрсөн долоо хоногт Монреаль хотод хэд хэдэн Анхны үндэстнүүдийн удирдагч нар Канадын Засгийн газрын 800 сая долларын хөрөнгө оруулалт, “Enduring Earth” байгууллагын хамтын ажиллагааг дэмжин байгаль хамгаалах дөрвөн төсөлд [ТБТС арга ашиглах хүсэлтэй байгаагаа мэдэгдсэн](#).

17 Анхны үндэстнүүдийн удирдагчдын манлайлсан “Great Bear Sea” санаачилга хамгийн эртний ой мод, цэнгэг усны системээс бүрдэх дэлхийн чухал ач холбогдолтой газар нутаг болох [Great Bear Rainforest](#)-ыг хамгаалах зорилгоор 2007 онд боловсруулсан Тогтвортой байдлын төслийн санхүүжилт (ТБТС)-ийн анхны загварын амжилтад тулгуурлана. Анхны үндэстнүүдээр манлайлуулсан “Great Bear Sea” санаачилгын алсын хараа Анхны үндэстнүүдийн олон мянган жилийн турш удирдаж ирсэн далайн амин чухал экосистемийг хамгаалах ажлын хамрах хүрээг өргөжүүлнэ. Холбооны дэмжлэг авах бусад 3 Уугуул иргэдийн манлайлсан Тогтвортой байдлын төслийн санхүүжилт (ТБТС) Хойд Онтарио дахь Омушкего байгаль хамгаалах төсөл; Нунавут дахь Кикиктани бүс; Баруун хойд нутаг дэвсгэр юм.

“The Nature Conservancy” байгууллагын ивээл доор “Enduring Earth” байгууллага, Габон, Монгол улсын дэмжсэн Тогтвортой байдлын төслийн санхүүжилт (ТБТС) төслүүдийг [Bezos Earth Fund](#), [Gordon and Betty Moore Foundation](#), [Margaret A. Cargill Philanthropies](#) сангийн буяны хандив туслалцаагүйгээр хэрэгжүүлэх боломжгүй байсан.

“The Nature Conservancy” байгууллага бүх амьдрал тогтдог газар нутаг, усыг хамгаалах зорилготой олон улсын байгаль хамгаалах байгууллага юм. Шинжлэх ухаанд тулгуурлан хүн, байгаль хамтдаа өсөн дэвжих боломжтой болгох зорилгоор бид дэлхийн хамгийн хүнд хэцүү сорилтуудад шинэлэг, шийдлүүдийг газар дээр нь бий болгодог. Бид уур амьсгалын өөрчлөлтийг хязгаарлаж, газар, ус, далайг урьд хожид байгаагүй өргөн хүрээнд хамгаалж, тогтвортой хүнс, усаар хангаж, хотуудыг илүү тогтвортой болгож байна. Бид 76 улс, нутаг дэвсгэрт ажиллаж байгаа ба эдгээрээс 37 нь шууд байгаль хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа. 39 нь түншүүдээрээ дамжуулан нутгийн иргэд, засгийн газар, хувийн хэвшил, бусад түншийг оролцуулсан хамтын ажиллагааны арга

барилыг баримталдаг. Илүү ихийг мэдэхийг хүсвэл www.nature.org уруу орж эсвэл Twitter дээр [@nature_press](https://twitter.com/nature_press) ба [@enduring_earth](https://twitter.com/enduring_earth) хаягийг дагаарай.